



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/43

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах сониныг хэвлүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталж, хавсралтад туссан аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т даалгасугай.

2.Дээрх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлж, хүлээн авахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Т.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

3.Гэрээний зардал 6,445,000 (зургаан сая дөрвөн зуун дөчин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газраас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010066

Аймгийн Засаг даргын 2025 оны...
дугаар сарын ...-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт



Төсвийн задаргаа

д/д	Арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Төсөв
1	Эх бэлтгэл	"Ашин Булган" ХХК	1,100,000
2	Хэвлэлийн зардал	"Тунхаг бичиг" ХХК	5,175,000
3	Тээврийн зардал	"Тунхаг бичиг" ХХК	170,000
Нийт			6,445,000